

**АГУУЛГА**

|  |    |
|--|----|
| 1.ОРШИЛ ХЭСЭГ .....  | 2  |
| 2.ХУГАЦААНЫ НОРМ ТОГТООХ ЗОРИЛГО .....   | 2  |
| 3.ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН АКТ, БАРИМТ БИЧГҮҮД .....   | 2  |
| 4.НЭР ТОМЬЁО БА ТОДОРХОЙЛОЛТ.....  | 3  |
| 5.ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ.....  | 3  |
| 6.АВТО ЗАМЫН ЗОРЧИХ ХЭСГИЙН ХУЧЛАГА, ХӨВӨӨ, ТУСГААРЛАХ ЗУРВАС, ҮЗЭГДЭХ ЗАЙД<br>ТАВИГДАХ ШААРДЛАГУУД..... | 4  |
| 6.1. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ.....   | 4  |
| 6.2. ЗОРЧИХ ХЭСГИЙН ХУЧЛАГА.....   | 5  |
| 6.3. ХӨВӨӨ БА ТУСГААРЛАХ ЗУРВАС .....  | 6  |
| 6.4. ҮЗЭГДЭХ ЗАЙН ШААРДЛАГА.....   | 7  |
| 7.ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ШААРДЛАГУУД .....                                | 7  |
| 7.1. ЗАМЫН ТЭМДЭГҮҮД .....   | 7  |
| 7.2. ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭ .....   | 8  |
| 7.3. ЗАМЫН ГЭРЛЭН ДОХИО .....  | 8  |
| 7.4. ЗАМЫН ХАЙС.....   | 9  |
| 7.5. ДОХИОНЫ ШОНГУУД БА ЗАМЫН ТҮМБЭ .....  | 9  |
| 7.6. ЗАМЫН ГЭРЭЛ ОЙЛГОГЧИД .....   | 10 |
| 7.7. ХИЙМЭЛ ОВГОРУУД (“ХЭВТЭЭ ЦАГДАА”).....  | 10 |
| 8.ГЭРЭЛТҮҮЛЭГИЙН ШААРДЛАГА .....   | 10 |
| 9.ӨВЛИЙН ЗАМЫН АШИГЛАЛТЫН БАЙДАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА.....  | 11 |

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИД ГАРСАН ГЭМТЭЛ СОГОГ, ЭВДРЭЛИЙГ ЗАСАХ  
ХУГАЦААНЫ НОРМ**

**A TIME-LIMIT FOR REPAIR OF ROADS AND ROAD  
FACILITIES DEFECTS**

**1. ОРШИЛ ХЭСЭГ**

- 1.1 Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн туршид, байгаль, цаг уурын ямар ч нөхцөлд саадгүй нэвтрүүлэхэд авто зам, замын байгууламжийг байнга бэлэн байлгах нь арчлалт, засварын ажлын эцсийн үр дүн, үндсэн зорилго мөн. Иймд энэ зорилгыг хангахын тулд ямар ч ангиллын замд хойшлуулшгүй хийгдэх ажлуудыг гүйцэтгэсэн байх хугацааны нормыг тухайн замын зэрэглэл, ач холбогдол, цаг уурын нөхцөл байдалтай уялдуулан тооцож тогтоох, улмаар хэрэглэхэдэнэхүү Авто зам, замын байгууламжийн гэмтэл согог, эвдрэлийг засах хугацааны норм (цаашид “хугацааны норм” гэх) чиглэгдэнэ.
- 1.2 Илүү хялбар, ойлгохоор болгож, хөрөнгө оруулалтын хамгийн бага хэмжээнд ч зайлшгүй баримтлах ёстой хөдөлгөөний аюулгүй байдалд шууд нөлөөлдөг үндсэн гол ажлуудын хугацааны нормуудыг шинэчлэн боловсруулав. 2016 онд батлагдсан хугацааны нормын, 1км замын хэмжээнд тооцогдсон “Тухайн саад эвдрэлийг арилгаж, зассан байх ёстой хугацаа, /цагаар/-  $T_{max}$ ” гэсэн дундач хязгаар цагийг, тухайн чиглэлийн замын нийт уртад хамаарахаар болгоод, хоногоор тооцож шинэчлэв.
- 1.3 Зам хариуцагч болон Зам эзэмшигчид, батлагдсан аргачлалаар, ХО-ын хэмжээ, замын ашиглалтын түвшинтэй уялдуулан тухайн бүс нутагт мөрдөгдөх хугацааны нормыг жил бүр шинэчлэн батлаад мөрдөж болно.
- 1.4 Энэхүү норм нь Монгол улсын Үндэсний авто замын сүлжээний замуудад хамаарна.

**2. ХУГАЦААНЫ НОРМ ТОГТООХ ЗОРИЛГО**

- 2.1. Авто зам, замын байгууламжийн ашиглалтын хугацааг уртасгах үндсэн нөхцөлийг бий болгоно.
- 2.2. Авто зам, замын байгууламж дээр үүсдэг элдэв хог, саад, нүх, жижиг эвдрэл зохих хугацаандаа арилж, засварлагдаж хэвийн болох ба ингэснээр тэдгээрээс үүдэнгарч болзошгүй зам, тээврийн ослыг бууруулах, гаргахгүй байх нөхцлийг бүрдүүлнэ.
- 2.3. Авто замын арчлалт, урсгал засварын байгууллагын /Зам хариуцагчийн/ үндсэн ажлын үзүүлэлтийг үнэлж, арчлалт, урсгал засварын ажлын гүйцэтгэлийг дүгнэх шалгуур болгох.

**3. ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН АКТ, БАРИМТ БИЧГҮҮД**

- Авто замын тухай хууль
- Авто зам, замын байгууламжийн арчлалт засварын зохион байгуулалтын журам” Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны... тоот тушаал
- “Авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажлын техникийн шаардлага” Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны... тоот тушаал

- Авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын түвшинг тогтоох, үнэлэх аргачлал MNS ASTM D 6441-2014
- Авто зам ба авто зогсоолын хучлагын ашиглалтын төлөвийн тоон үнэлгээний арга MNS ASTM D 6433 : 2009
- Авто замын тэмдэг болон дохионы төмөр бетон шон. Техникийн шаардлага MNS 4912 : 2016
- Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага MNS 4759-2014
- Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596-2014
- Авто замын долгионт төмөр хайс. Техникийн шаардлага MNS AASHTO M 180 : 2004
- Шон суурьтай замын тэмдэг. Замын гэрэлтдэг тэмдэг MNS EN 12966 : 2016
- Замын тэмдгийн гэрэл ойлгогч Техникийн шаардлага MNS ASTM D 4956-2005
- Авто замын гэрлэн дохио. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4980-2014
- Асфальтбетон хучлагын засвар: Ерөнхий нөхцлүүд
- Авто замын цементбетон хучлагын арчлалт, засварын аргачилсан заавар
- Авто замын тэмдэг, тэмдэглэгээ, тоноглол, үйлчилгээний байгууламжийн арчлалт засварын ажлын аргачилсан заавар
- Явган болон дугуйн замын арчлалт, засварын ажлын аргачилсан заавар
- Авто замын гүүрийн байгууламжийн арчлалт, засварын ажлын аргачилсан заавар
- Авто замын өвлийн арчлалтын заавар
- “Авто зам, гүүрийн арчлалт, засварын ажлын зардлын суурь норм 33БД 84-021-2016” Сангийн сайд, зам, тээврийн хөгжлийн сайдын хамтарсан 2016 оны 4-р сарын 26-ны өдрийн 152/101 дугаар тушаал
- “Авто замын ашиглалтын бэлэн байдлын түвшингээр санхүүжүүлэх журам” Сангийн сайд, Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 154/А/159 тоот тушаалын хавсралт

Эдгээр баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд, хүчин төгөлдөр болж баталгаажсан сүүлчийн хувилбарыг хэрэглэж, тэдгээрийн заалтад нийцүүлнэ.

#### 4. НЭР ТОМЬЁО БА ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1. Гэмтэл согог -дефект:** Авто зам, замын байгууламж, түүний тоноглолын элементүүдийн техник ашиглалтын үзүүлэлтүүд нь Техникийн шаардлага, норм стандартад нийцэхгүй болсон байх гажиг
- 4.2. Илрүүлсэн цаг мөч:** Зам хариуцагч байгууллагыг төлөөлөх эрх бүхий этгээд нь гэмтэл гарсан тухай мэдээлэл авч, түүнийг баталгаажуулан бүртгэсэн огноо, цаг
- 4.3. Гэмтэл арилгасан хугацаа:** Гэмтэл илэрсэн цаг мөчөөс түүнийг арилгасан цаг мөч хүртэлх хамгийн их хугацаа. *Тодруулга: Зам тээврийн ослоос шалтгаалж, замын байгууламж, тоноглол эвдэлсэн тохиолдолд, хохирлын нөхөн төлбөрөө хийсэн тэр мөчөөс, гэмтэл арилгах хугацааг тооцдог.*
- 4.4. Замын ашиглалтын байдал:** Авто зам, замын байгууламж, түүний тоноглолын элементүүдийн техник ашиглалтын үзүүлэлтүүд нь тээврийн хэрэгслийн үйлчлэл болон байгаль цаг уурын нөлөөллийн улмаас, замын ашиглалтын явцад хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулсан замын байдал.

#### 5. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 5.1. Замын ашиглалтын байдалд тавигдах шаардлагыг,** Авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын түвшинг тогтоох, үнэлэх аргачлал MNS ASTM D 6441-2014 ба Авто зам ба авто зогсоолын хучлагын ашиглалтын төлөвийн тоон үнэлгээний арга MNS ASTM D 6433 : 2009 стандартууд, Авто замын ашиглалтын

- байдлын үнэлгээ хийх програм хангамж болон энэхүү норм дүрмээр тодорхойлно.
- 5.2.** Хэрэв зам дээр үүссэн эвдрэл гэмтлийг тогтоосон хугацаанд арилгах боломжгүй, замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх бодит нөхцөл байдал үүссэн тохиолдолд (тухайлбал, энэ нормын 1.3 тусгасан нөхцөл г.м), Зөвлөх Захиалагч хамтран түр баримтлах хугацааны хязгаар тогтоож болох бөгөөд энэ нь хуулийн дагуу хүлээх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй, зөвхөн Зам хариуцагчтай байгуулсан гэрээний нэмэлт тодруулга болно.
- 5.3.** Гэмтлийг арилгах ажил гүйцэтгэх технологийн шаардлагаар, цаг агаарын тодорхой нөхцөл заасан тохиолдолд, гэмтлийг арилгах хугацааг, тийм нөхцөл эхэлсэн үеэс тооцно.
- 5.4.** Хучилтын зорчих хэсэг дээр гарсан, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн саад учруулж, тойрч гарах, хурд огцом хасах нөхцөл бүрдүүлж байгаа нүх, овойлт, дугуйн мөрөөрх хотойлт, шугам сүлжээ, далд ус зайлуулалтын онгорхой таг, мөн түүнчлэн зам дээр бий болсон том хэмжээний зүйл /эвдэрхий замын тоноглол, том чулуу, дайрагдсан мал амьтан, унасан ачаа г.м/-ээс сэргийлсэн тэмдэг хаалт, заалтыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлэн, энэхүү нормын дагуу, заасан хугацаанд багтаан тавина. Замын хөдөлгөөн зохицуулах эдгээр түр тэмдэг заалтыг, гэмтэл бүрэн арилгах хугацаанд, тэдгээрийг тавьсан шалтгааныг арилтал тэмдэг тавьсан байгууллага нь 1 хоногийн хугацаанд хариуцана.
- 6. АВТО ЗАМЫН ЗОРЧИХ ХЭСГИЙН ХУЧЛАГА, ХӨВӨӨ, ТУСГААРЛАХ ЗУРВАС, ҮЗЭГДЭХ ЗАЙД ТАВИГДАХ ШААРДЛАГУУД**
- 6.1. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**
- 6.1.1. Авто замын зорчих хэсгийн хучлага, хөвөө, тусгаарлах зурвас дээр ямар нэгэн гадны биет, хог шороо байх ёсгүй бөгөөд эдгээр зөрчлийг энэхүү нормд заасан хугацаанд арилгасан байх
- 6.1.2. Замын зорчих хэсгийн хучлага, тусгаарлах зурвасын аюулгүй хэсэг, хөвөөний зах ирмэг нь бүх ангиллын замын хувьд 1м<sup>2</sup> ба түүнээс их, ашиглалтын байдлын бүх түвшинд 40м/км болон түүнээс урт хэмжээнд ямар нэгэн бохирдолгүй байх ёстой. Хүснэгт 1-д замын ашиглалтын түвшинтэй уялдсан замын цэвэрлэгээ хийж хогийг зайлуулах хугацааг харуулав.

**Хүснэгт 1. Замын цэвэрлэгээг хийсэн байх ёстой хамгийн бага хугацаа**

| <b>Замын ашиглалтын түвшин</b> | <b>Ашиглалтын тухайн түвшинд байх ёстой замын ач холбогдол, ангилал<sup>1</sup>, эсвэл хоногийн дундач хөдөлгөөний эрчим (ХДХЭ)</b>  | <b>Замын зорчих хэсэг, зурвасыг цэвэрлэсэн байх ёстой хугацаа</b> |
|--------------------------------|--|---|
| <b>АТ-1</b>                    | АН-3, АН-4, АН-32 дугаартай Азийн авто замын сүлжээнд орсон Олон улсын чанартай авто зам, Хөшгийн хөндий чиглэлийн хурдны зам, Нийслэлийн авто замууд, <b>ХДХЭ &gt;10000 маш/хон</b> | 0.1-0.5 хоног   |
| <b>АТ-2</b>                    | 1-р түвшингийн олон улсын чанартай замтай давхцаагүй улсын чанартай авто замууд, <b>ХДХЭ &gt;5000-10000 маш/хон</b>  | 1-1,5 хоног   |
| <b>АТ-3</b>                    | Тусгай зориулалтын авто замууд, <b>ХДХЭ &gt;1000-5000 маш/хон</b>  | 1,5 хоног   |
| <b>АТ-4</b>                    | Орон нутгийн чанартай авто замууд, <b>ХДХЭ &gt;200-1000 маш/хон</b>  | 3 хоног   |
| <b>АТ-5</b>                    | 3 ба 4-р түвшингийн замд хамраагүй улирлын чанартай замууд, аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын авто замууд, <b>ХДХЭ &lt;200 маш/хон</b>  | 5 хоног   |

**Тодруулга:** <sup>1</sup>Авто замын ангиллуудыг Авто замын тухай хуулийн 15-р зүйлийн дагуу тогтоох бөгөөд мөн хуулийн 17-р зүйлийн дагуу зам эзэмшигчид, ашиглалтын түвшингээр тогтоож болно

**6.2. ЗОРЧИХ ХЭСГИЙН ХУЧЛАГА**

6.2.1. Замын зорчих хэсгийн хучлагын дагуух тэгш байдал нь хөдөлгөөний аюулгүй нөхцлийг хангаж байх ёстой бөгөөд бүх түвшингийн замын хувьд Хүснэгт 2-т заасан утгаас хэтэрч болохгүй.

**Хүснэгт 2. Хучлагын тэгш байдлын үзүүлэлтийн утгууд**

| <b>Замын ашиглалтын түвшин</b> | <b>Ашиглалтын тухайн түвшинд байх ёстой замын ач холбогдол, ангилал, эсвэл хоногийн дундач хөдөлгөөний эрчим (ХДХЭ)</b>   | <b>Тэгш байдлын олон улсын индекс IRI, м/км, ихгүй</b> |
|--------------------------------|---|--|
| <b>АТ-1</b>                    | АН-3, АН-4, АН-32 дугаартай Азийн авто замын сүлжээнд орсон Олон улсын чанартай авто зам, Хөшгийн хөндий чиглэлийн хурдны зам, Нийслэлийн чанартай авто замууд, <b>ХДХЭ &gt;10000 маш/хон</b> | 2,0-3,5  |
| <b>АТ-2</b>                    | 1-р түвшингийн олон улсын чанартай замтай давхцаагүй улсын чанартай авто замууд, <b>ХДХЭ &gt;5000-10000 маш/хон</b>   | 3,6-4,0  |
| <b>АТ-3</b>                    | Тусгай зориулалтын авто замууд, <b>ХДХЭ &gt;1000-5000 маш/хон</b>   | 3,6-4,5  |
| <b>АТ-4</b>                    | Орон нутгийн чанартай авто замууд, <b>ХДХЭ &gt;200-1000 маш/хон</b>   | 4,6-5,5  |
| <b>АТ-5</b>                    | 3 ба 4-р түвшингийн замд хамраагүй улирлын чанартай замууд, аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын авто замууд, <b>ХДХЭ &lt;200 маш/хон</b>   | 5,6-6,5  |

**Хүснэгт 2<sup>1</sup>. Авто замын хучилтын ерөнхий байдлын /TAT-PCI/ үзүүлэлтийн утгууд**

| <b>Замын ашиглалтын түвшин</b> | <b>Ашиглалтын тухайн түвшинд байх ёстой замын ач холбогдол, ангилал, эсвэл хоногийн дундач хөдөлгөөний эрчим (ХДХЭ)</b>   | <b>TAT-PCI буюу ашиглалтын түвшин, %</b> |
|--------------------------------|---|--|
| <b>АТ-1</b>                    | АН-3, АН-4, АН-32 дугаартай Азийн авто замын сүлжээнд орсон Олон улсын чанартай авто зам, Хөшгийн хөндий чиглэлийн хурдны зам, Нийслэлийн чанартай авто замууд, <b>ХДХЭ &gt;10000 маш/хон</b> | >95                                      |
| <b>АТ-2</b>                    | 1-р түвшингийн олон улсын чанартай замтай давхцаагүй улсын чанартай авто замууд, <b>ХДХЭ &gt;5000-10000 маш/хон</b>   | 85-95                                    |
| <b>АТ-3</b>                    | Тусгай зориулалтын авто замууд, <b>ХДХЭ &gt;1000-5000 маш/хон</b>   | 80-90                                    |
| <b>АТ-4</b>                    | Орон нутгийн чанартай авто замууд, <b>ХДХЭ &gt;200-1000 маш/хон</b>   | 70-80                                    |
| <b>АТ-5</b>                    | 3 ба 4-р түвшингийн замд хамраагүй улирлын чанартай замууд, аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын авто замууд, <b>ХДХЭ &lt;200 маш/хон</b>   | 70-75                                    |

- 6.2.2. Замын хучлагын тэгш байдал ба техник ашиглалтын түвшин /ТАТ/-г Авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын түвшинг тогтоох, үнэлэх аргачлал MNS ASTM D 6441-2014 стандартад заасан аргачлалаар хэмжинэ.
- 6.2.3. Автомашины дугуйны хучлагатай барьцалдах илтгэлцүүр нь 0.3-с багагүй байна. Замын тэгш байдлыг сайжруулах, барьцалдах илтгэлцүүрийг хангах хугацааг холбогдох стандартуудын дагуу тогтоодог.
- 6.2.4. Замын зорчих хэсгийн хучлага нь Хүснэгт 3-д заасан гэмтэл эвдрэлгүй байна.

### 3. Хучлагын эвдрэл гэмтэл, түүнийг засах хугацаа

| Гэмтэл, эвдрэлийн төрөл  | Ашиглалтын байдлын түвшин | Замын ангилал                      | Хэмжээ | Засах хугацаа, хоногоос хэтрэхгүй |
|--|---------------------------|------------------------------------|--------|-----------------------------------|
| Хатуу болон хөнгөвчилсөн төрлийн авто замын хучилтын хучлага   |                           |                                    |        |                                   |
| 5см ба түүнээс их гүнтэй, ...м <sup>2</sup> -с багагүй хэмжээтэй хэсэгчилсэн нүх болон цөмрөлт   | АТ-1                      | ОУЧ <sup>1</sup> , НЧ <sup>2</sup> | 0,04   | 2                                 |
|  | АТ-2                      | УЧ <sup>3</sup>                    |        | 3-4                               |
|  | АТ-3                      | ОНЧ <sup>4</sup> , ТЗ <sup>5</sup> |        | 4-5                               |
|  | АТ-4                      | Бусад <sup>6</sup>                 |        | 7                                 |
| Дугуйн мөрөөрх хотойлт, ...см ба түүнээс их  | АТ-1                      | ОУЧ, НЧ                            | 1,0    | нормчлохгүй                       |
|  | АТ-2                      | УЧ                                 | 2,0    |                                   |
|  | АТ-3 ба 4                 | бусад                              | 4,0    |                                   |
| Шилжилт ба долгион үүссэн гүн ...см ба түүнээс их  | Бүх түвшинд               | ОУЧ, НЧ                            | 3,0    | 5                                 |
|  |                           | УЧ                                 | 5,0    | 7                                 |
|  |                           | бусад                              |        | 10                                |
| <i><sup>1</sup>ОУЧ-Олон улсын чанартай авто зам, <sup>2</sup>НЧ-Нийслэлийн авто зам, <sup>3</sup>УЧ-Улсын чанартай авто зам, <sup>4</sup>ОНЧ-Орон нутгийн чанартай авто зам, <sup>5</sup>-ТЗ-Тусгай зориулалтын авто зам, <sup>6</sup>-Байгууллагын дотоодын авто зам, ачиж буулгах терминалууд, нийтийн хэрэглээний авто зогсоолууд</i> |                           |                                    |        |                                   |

Хучлагын эвдрэл гэмтлийн хэмжилтийг Авто зам, замын байгууламжийн техник ашиглалтын түвшинг тогтоох, үнэлэх аргачлал MNS ASTM D 6441-2014 ба Авто зам ба авто зогсоолын хучлагын ашиглалтын төлөвийн тоон үнэлгээний арга MNS ASTM D 6433 : 2009 стандартууд, Авто замын ашиглалтын байдлын үнэлгээ хийх програм хангамжид нийцүүлэн гүйцэтгэнэ.

- 6.2.5. Хэв гажилтын заадсын орчинд 3 см-с их гүнтэй гажилт гарахыг зөвшөөрөхгүй бөгөөд гарсан тохиолдолд 3 хоногийн дотор арилгана.
- 6.2.6. Төмөр замын гарман дээр рельс хооронд байрлуулсан тавцангийн түвшингийн өндөржилт ±1см-ээс хэтрэхгүй байх бөгөөд үүнээс их гажилт үүсч, цохилт гарч эхэлбэл, ажиглагдсан мөчөөс эхлээд 2 хоногийн дотор засч тэгшилнэ.
- 6.2.7. Шугам сүлжээний таглаа, борооны ус зайлуулагчийн тор, ус хураагч худгийн тагийн өндөржилтийн түвшин нь хучлагын түвшинтэй чацуу буюу ±1см-ээс хэтрэхгүй зөрүүтэй байх ёстой бөгөөд үүнээс хэтэрсэн тохиолдолд 2 хоногийн дотор засна. Харин люк нь хагарч хэмхэрсэн таглаа, тортой байхыг зөвшөөрөхгүй бөгөөд ийм эвдрэл гарсан тохиолдолд 1 хоногийн дотор солино.

### 6.3. ХӨВӨӨ БА ТУСГААРЛАХ ЗУРВАС

- 6.3.1. Хөвөө ба тусгаарлах зурвас нь Хүснэгт 4-д заасан хэмжээний эвдрэл, гажиггүй байна.

Хүснэгт 4. **Хөвөө ба тусгаарлах зурвасын эвдрэл гэмтэл, түүнийг засах**

хугацаа

| Гэмтэл, эвдрэлийн төрөл   | Ашиглалтын байдлын түвшин | Замын ангилал                      | Хэмжээ | Засах хугацаа, хоногоос хэтрэхгүй |
|---|---------------------------|------------------------------------|--------|-----------------------------------|
| Замын хашлагагүй тохиолдолд зорчих хэсэгтэй нийлсэн хэсэгт гарсан шилжилтийн хучилт ба хучлагагүй хөвөөний суулт, ...см ба түүнээс их | бүх түвшинд               | ОУЧ <sup>1</sup> , НЧ <sup>2</sup> | 1,5    | 3                                 |
|   |                           | УЧ <sup>3</sup>                    | 2      | 5                                 |
|   |                           | ОНЧ <sup>4</sup> , ТЗ <sup>5</sup> | 3      | 7                                 |
|   |                           | Бусад <sup>6</sup>                 | 4      | 10                                |
| Аюулгүйн зурвас болон хучлагын ирмэг дээр үүссэн 5см ба түүнээс илүү гүнтэй, ... м <sup>2</sup> -с багагүй талбайтай нүх ба цөмөрхий  | АТ-1                      | ОУЧ, НЧ                            | 0,09   | 3                                 |
|   | АТ-2                      | УЧ                                 |        | 5                                 |
|   | АТ-3 ба 4                 | бусад                              |        | 7                                 |
|   | -                         |                                    |        | 10                                |
| Хөвөөн дээр гарсан 5см ба түүнээс их гүнтэй, ... м <sup>2</sup> -с багагүй талбайтай хэсэгчилсэн зурвас ховил ба нүх                  | АТ-1                      | ОУЧ, НЧ                            | 0,09   | 2                                 |
|   | АТ-2                      | УЧ                                 |        | 4                                 |
|   | АТ-3 ба 4                 | бусад                              |        | 6                                 |

<sup>1</sup>-Олон улсын чанартай авто зам, <sup>2</sup>-Нийслэлийн авто зам, <sup>3</sup>-Улсын чанартай авто зам, <sup>4</sup>-Орон нутгийн чанартай авто зам, <sup>5</sup>- Тусгай зориулалтын авто зам, <sup>6</sup>- Байгууллагын дотоодын авто зам, ачиж буулгах терминалууд, нийтийн хэрэглээний авто зогсоолууд

6.3.2. Тусгаарлах зурвасны аюулгүйн зурвас, хөвөөний захын зурвасын тэгш байдал нь замын ангиллаас хамаарч Хүснэгт 2-т заасан хэмжээнд байна.

#### 6.4. ҮЗЭГДЭХ ЗАЙН ШААРДЛАГА

6.4.1. Үзэгдэх зайг хангахын тулд дараах бүсэд, замын хөдөлгөөнийг зохицуулах техник хэрэгсэлээс бусад 0,5м-ээс өндөртэй шороо болон цасан овоолго үүсгэх, мод бут тарих, сурталчилгааны самбар байршуулахыг зөвшөөрөхгүй:

- Зохицуулалтгүй замуудын огтлолцол, нэг түвшингийн замын уулзвар, мөн түүнчлэн явган хүний гармын үзэгдэлтийн гурвалжинд
  - Хэвтээ талбай дээрх муруйн дотор талын үзэгдэлтийн огтлолцолд
  - Замын тэмдэгний заалтыг хаасан байршилд
- Хэрэв ийм зөрчил гарвал 3 хоногийн дотор арилгана.

6.4.2. Төмөр замын хаалтгүй гармыг, ойртож байгаа галт тэрэг чөлөөтэй харагдах цэг дээр гаргах бөгөөд энэ үзэгдэх зайн хангалтын шаардлагыг 6.4.1-д заасантай ижлээр тогтмол хангана.

6.4.3. Үзэгдэх зайг муутгасан, түүн дотроо замын тэмдэг, гэрлэн дохиох далдалсан бүх шалтгааныг 3 хоногийн дотор арилгана.

### 7. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН ШААРДЛАГУУД

#### 7.1. ЗАМЫН ТЭМДЭГҮҮД

7.1.1. Замын тэмдэгийн нүүрэн тал нь цэвэрхэн, ямар нэгэн толбо зураасгүй, цас мөс наалдаагүй, замын тэмдэг заалтын бичвэрийг таньж мэдэж, дагахад эргэлзээгүй байх, энэ талын зөрчил үүссэн тохиолдолд, илэрсэн мөчөөс эхлээд нэг хоногийн дотор арилгах

7.1.2. Зайлшгүй байх шаардлагатай тэмдэг заалтыг 1 хоногийн дотор нөхөж тавих, харин бусдыг илэрсэн өдрөөс хойш 3 хоногийн дотор байрлуулах.

7.1.3. Бүх ангиллын, ашиглалтын бүх түвшингийн авто замын, тэмдэг заалт (цаашдаа тэмдэг гэх), мэдээлэл нь солигддог тэмдэгүүд (цаашдаа МСТ гэх) дараах гэмтэл гажиггүй байна:

- Төрөл бүрийн шалтгаанаар, тэмдэгний дүрсний дурын элементийн талбайн 25% ба түүнээс их ховхорсон, цахилгаан-механик МСТ-ний нэгж бичлэг гацсан, анивчсан, асахгүй болсон бол 3 хоногийн дотор,
- Тэмдэгний гэрэл ойлгогч нэгж илтгэлцүүр, тэмдэгний ба МСТ-ний хурц тусгалын илтгэлцүүр нь нормативт утгаас багасч ихээхэн буурсан бол илэрснээс хойш 5 хоногийн дотор
- Тэмдэгнүүдийн дундач хурц тусгал ба гэрэлтүүлэг нормативт утганаас багасч буурсан бол илэрснээс хойш 4 хоногийн дотор
- МСТ-ний дурын элементийн гэрэл цацруулагч диодын 20% нь ажиллагаагүй болсон бол илрүүлснээс хойш 4 хоногийн дотор тус тус засварлана.

## **7.2. ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭ**

7.2.1. Замын тэмдэглэгээ нь дараах эвдрэлгүй байх ёстой:

- Тэмдэглээний элэгдсэн болон арилсан талбайн хэмжээ нь “Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага MNS 4759-2014”-д заасан утганаас хэтэрсэн бол ийм зөрчил илэрснээс хойш 25-30 хоногийн дотор засна.
- Хурц тусгалын илтгэлцүүр, гэрэл ойлтын нэгж илтгэлцүүр ба гэрэл цацруулалтын нэгж илтгэлцүүрийн утга нь байгалийн болон ердийн гэрэлтүүлгийн үед MNS 4759-2014 стандартаар тогтоосноос доошилж буурсан бол 30 хоногийн дотор засна.

## **7.3. ЗАМЫН ГЭРЛЭН ДОХИО**

7.3.1. Замын гэрлэн дохионы суурилуулалт, ажиллах дэглэмийн тохиргоо нь “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596-2014”-ын шаардлагад нийцсэн байна.

7.3.2. Замын гэрлэн дохио ба түүний гэрэл нь замын бүх ангилалд Хүснэгт 5-д заасан, гэрлийн харагдалтыг бууруулсан ба хөдөлгөөний аюулгүй байдлыг үл хангасан эвдрэл гэмтэл гажиггүй байна.

### **Хүснэгт 5. Замын гэрлэн дохионы эвдрэл гэмтэл, түүнийг засах хугацаа**

| Эвдрэл гэмтэл, гажгийн төрөл   | Замын ангилал           | Засах хугацаа, хоногоос хэтрэхгүй |
|--|-------------------------|-----------------------------------|
| Гэрлийн болон гэрлийн диодын модулийн нэг эх үүсвэр эвдэрсэн   | Авто замын бүх ангилалд | 1                                 |
| Гэрлэн дохионы цахилгааны монтаж, цахилгааны кабельд гэмтэл гарсан   |                         | 2                                 |
| Цацруулагчид гэмтэл гарсан, дүрс бүхий талбайн 25% нь сарниулагчийн гадаргуугаас ховхорсон, халхавч болон сарниулагч эвдэрсэн /байхгүй/, төрөл бүрийн шалтгаанаас үүдэж сарниулагчийн талбайн 20%-с их нь бохирдсон  |                         | 5                                 |
| Гэрлэн дохионы нэг гэрлийн модулийн гэрэл цацруулагч диодын 20-с дээш % нь ажиллагаагүй болсон, гэрлийн тэнхлэгийн хүч 30-с дээш %-р буурсан. Гэрлэн дохионы тод, ялгарах гэрэл нь шөнийн цагт MNS 4596-2014-р тогтоосон шаардлагад нийцэхгүй байх   |                         | 7                                 |
| Гэрлэн дохионы объектыг салгаж, “анивчсан шар” ослын дэглэмд шилжсэн, гэрлэн дохионы гэрлүүд нь стандартын бус болсон  |                         | 1                                 |
| Зөрчилтэй чиглэл бүрт хөдөлгөөн зөвшөөрсөн гэрлэн дохионы гэрлийг зэрэг залгасан, үүний уршгаар замын гэрлэн дохионы ажлыг удирдах төхөөрөмжийн үйл ажиллагаанд саатал гарсан. Нэг чиглэлийн /үндсэн ба орлох/ тээврийн хэрэгсэлийн ба явган зорчигчийн хөдөлгөөнийг зохицуулах улаан гэрлийг салгасан |                         | 1                                 |
| Явган зорчигчийн дуудсан дэлгэцэнд саатал гарсан   |                         | 3                                 |



**7.4. ЗАМЫН ХАЙС**

- 7.4.1. Автомашинд зориулсан замын хайс нь “Авто замын долгионт төмөр хайс. Техникийн шаардлага MNS AASHTO M 180 : 2004” стандартын шаардлагад нийцсэн байна.
- 7.4.2. Замын хайс нь түүний тогтоох чанарыг бууруулсан, Хүснэгт 6-д заасан эвдрэл гэмтэлгүй байна.

**Хүснэгт 6. Замын хайсны эвдрэл гэмтэл, түүнийг засах хугацаа**

| Эвдрэл гэмтэл, гажгийн төрөл   | Ашиглалтын байдлын түвшин | Замын ангилал | Засах хугацаа, хоногоос хэтрэхгүй |
|--|---------------------------|---------------|-----------------------------------|
| Хайсны нуруу, багана байхгүй. 1м-ийн алхамтай бага хооронд, хашлага тросон аргамж нь 0,6см ба илүү хэмжээгээр унжсан. Трос тасарч, “өргөс” үүссэн.   | АТ-1                      | -             | 2                                 |
| Төмөрбетон хайсны элементүүд дээр торон хагарал үүссэн, бетон нь арматур хүртлээ хагарсан  | АТ-2                      | ОУЧ, НЧ       | 3(2)                              |
| Нуруунуудыг хооронд нь холбосон бэхэлгээний элементүүдийн 50%-с ихэнх нь байхгүй болсон  | -                         | уч            | 5(3)                              |
| Аль нэг бэхэлгээний зангилаа <sup>1</sup> ны дор хаяж нэг бэхэлгээний элемент байхгүй болсон болон гагнуур салсан  | АТ-3                      | бусад         | 7(5)                              |
| 20 м ба түүнээс дээш урттай хайсны хэсгийн бэхэлгээний элементийн 25%-с дээших нь байхгүй болсон   | АТ-4, 5                   | бусад         | 10(7)                             |
| Явган зорчигчийн замын хайсны элементүүд эвдэрсэн ба байхгүй болсон  | -                         |               | 5                                 |
| <i><sup>1</sup> -бэхэлгээний зангилаа- нурууг компенсатортой /консольтой/, компенсатор /консолийг/ багана шонтой, шонг гүүрийн байгууламжийн эд ангитай холбосон бэхэлгээг хэлнэ.<br/>Тодруулга: Хаалтан дотор гүүрийн байгууламжин дээр гарсан эвдрэл гэмтлийг засах хугацааг харуулав.</i> |                           |               |                                   |

**7.5. ДОХИОНЫ ШОНГУУД БА ЗАМЫН ТҮМБЭ**

- 7.5.1. Замын дохионы шон гэж замын чиглэл, шороон далангийн хязгаарыг заах, мөн тээврийн урсгалыг тусгаарлах зориулалттай, чиглүүлэгч шонгуудыг хэлнэ. Шонгуудыг дотор нь
- Ш1- дахин хэрэглэх зориулалтгүй (хөдөлгөөний эрчим 2000 маш/хон -с бага замд)
  - Ш2- дахин суурилуулж, олон дахин (хурдны замаас бусад бүх замд) хэрэглэх зориулалттай
  - Ш3- олон дахин хэрэглэх зориулалттай ба эгц босоо байдлаар сэргэдэг (бүх ангиллын замд хэрэглэдэг) гэж 3 хуваадаг.
- 7.5.2. Дохионы шон нь “Авто замын тэмдэг болон дохионы төмөр бетон шон. Техникийн шаардлага MNS 4912 : 2016”-ын шаардлагад нийцсэн байна.
- 7.5.3. Замын түмбэ гэж замын хөдөлгөөн зохион байгуулалтад бусад техникийн хэрэгсэлтэй хамтарч хэрэглэгддэг, гэрэл ойлгогч бүхий, цохилтод тэсвэртэй, чиглүүлэгч бүтээцэд хамаардаг, авто замын тоноглолын элементийг хэлдэг. Түмбэ нь ямар ч эстетик (гэхдээ голдуу дөрвөлжин байдаг) хэлбэртэй байж болох бөгөөд өндөр (0,75м-1,7м) , өргөн (1,30м-2,0м), урт (1,30м ба түүнээс их) гэсэн 3 хэмжээстэй байх бөгөөд тэгшхэн хавтгай гадаргуу дээр тусгай аргаар бэхэлж байршуулдаг.

7.5.4. Хугарсан, байхгүй байгаа дохионы шонг эвдрэл гэмтэл илэрснээс хойш 10 хоногийн дотор солих буюу шинээр тавина. Гэмтэл илэрснээс хойш 14 хоногийн дотор замын босоо тэмдэглэгээг сэргээнэ.

7.5.5. Түмбэний ажиллагаагүй болсон хиймэл гэрлийн эх үүсвэрийг, илэрснээс хойш 1 хоногийн дотор солино

**7.6. ЗАМЫН ГЭРЭЛ ОЙЛГОГЧИД**

7.6.1. Замын гэрэл ойлгогчид (катафот-КД) гэж гэрэл ойлгогч хальсан төрлийн, призм, бөөрөнхий төрлийн, хараа зүйн ойлгогч элементүүдийг агуулсан гэрлэн-дохиоллын төхөөрөмж самбарыг хэлнэ.

7.6.2. Гэрэлтүүлэггүй замын хэсэг дээр дараалсан 3 гэрэл ойлгогч байхгүй байхыг зөвшөөрөхгүй бөгөөд ийм байдал илэрснээс хойш 14 хоногийн дотор гэрэл ойлгогч (гэрэл ойлгогч элемент)-ийг сэргээнэ.

**7.7. ХИЙМЭЛ ХУРД СААРУУЛАГЧ**

7.7.1. Хиймэл хурд сааруулагчид гэж, авто замын зорчих хэсэг дээр хөдөлгөөний хурдыг албадан саатуулахын тулд, замын тэнхлэгт перпедикюляраар, зориудаар хийсэн угсармал болон цулаар бий болгосон овгоруудыг хэлнэ. Монголчуудын дунд “хэвтээ цагдаа” нэрээр алдаршжээ.

7.7.2. Хиймэл хурд сааруулагчид нь Хүснэгт 7-д заасан, хийцийн бүрэн бүтэн байдлыг сэргөөр нөлөөлсөн гэмтэл, эвдрэлгүй байна.

**Хүснэгт 7. Хиймэл хурд сааруулагчдын гэмтэл эвдрэл, түүнийг засах хугацаа**

| Эвдрэл гэмтэл, гажгийн төрөл  | Ашиглалтын байдлын түвшин | Замын ангилал | Засах хугацаа, хоногоос хэтрэхгүй |
|---|---------------------------|---------------|-----------------------------------|
| Хиймэл хурд сааруулагч дээр 2см ба түүнээс дээш өндөртэйгээр нэмэгдсэн, бэхэлгээний элементүүд сугарч гарсан /голцуу угсармал овгорууд дээр/, эсвэл дугуйн мөрөөр хотойж овгор биш болсон зарим элементүүдтэй | АТ-2                      | НЧ, УЧ, ОНЧ   | 3                                 |
| Хиймэл хурд сааруулагчийн нэг элементийн бэхэлгээний 2 болон түүнээс дээш бэхэлгээ байхгүй болсон   | АТ-3 ба АТ-4              | НЧ, УЧ, ОНЧ   | 5                                 |

**8. ГЭРЭЛТҮҮЛЭГИЙН ШААРДЛАГА**

8.1. Замын зорчих хэсгийн хучлагын гадаргуугийн тод харагдах байдал ба гэрэлтүүлэг нь Монгол улсын холбогдох стандартын шаардлагыг хангасан байна.

8.2. Замын гэрэлтүүлэг нь Хүснэгт 8-д тодорхойлсон ямар нэгэн гэмтэл, согоггүй байна.

**Хүснэгт 8. Замын гэрэлтүүлэгийн гэмтэл согог, түүнийг засах хугацаа**

| Гэмтэл согогийн төрөл  | Замын ангилал | Засах хугацаа, хоногоос хэтрэхгүй |
|--|---------------|-----------------------------------|
| Суурин газрын гаднах замын хэсэг дээрх ажиллагаагүй болсон гэрэлтүүлэгчийн тоо нь нийт гэрэлтүүлэгчийн 5%-с хэтэрсэн | ОУЧ, УЧ       | 3                                 |

|   |                   |   |
|---|-------------------|---|
| Дараалсан гэрэлтүүлэгчийн 2 ба түүнээс дээших нь асахгүй болсон   |                   | 2 |
| Явган хүний гарцан дээр, нэг төвшний уулзвар дээр, автобусны зогсоол дээр, замын гарц орцон дээрх гэрэлтүүлэгч ажиллахгүй болсон            | НЧ, УЧ            | 1 |
| Цахилгааны утас тасарснаас, шон хугарсанаас, гулзайж хазайснаас шалтгаалан гаднах гэрэлтүүлэгийн төхөөрөмжийн үйл ажиллагаанд саатал гарсан | бүх ангиллын замд | 2 |

**9. ӨВЛИЙН ЗАМЫН АШИГЛАЛТЫН БАЙДАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

**9.1.** Замын өвлийн арчлалтын ажлыг зохион байгуулах төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны гүйцэтгэлийг хангахуйц зам, замын байгууламжийн хийц хэсгүүдийн ашиглалтын байдал нь Авто замын өвлийн арчлалтын заавар, Техникийн шаардлагад нийцсэн байна.

**9.2.** Авто замын өвлийн ашиглалтыг мөн жишиг байдлаар АТ-1, АТ-2, АТ-3, АТ-4, АТ-5 гэсэн таван түвшинд ангилж хуваадаг. Хүснэгт 9-д Авто замын өвлийн арчлалтаар зайлшгүй хийх ёстой ажлуудын хугацааны нормыг авто замын ашиглалтын түвшин бүрээр харуулав.

**Хүснэгт 9. Хучлага дээр халтиргаанаас хамгаалах материал (ХХМ) цацах ба хучлага болон хөвөөний цасыг цэвэрлэх ажлын хугацааны норм**

| Замын ашиглалтын түвшин | Хугацааны норм, цагаар |                |                         |                | Хугацааны норм, хоног                |                |
|-------------------------|------------------------|----------------|-------------------------|----------------|--------------------------------------|----------------|
|                         | ХХМ цацах              |                | Хучлагын цасыг цэвэрлэх |                | Зогсох талбай ба хөвөөний цэвэрлэгээ |                |
|                         | Жирийн нөхцөлд         | Ноцтой нөхцөлд | Жирийн нөхцөлд          | Ноцтой нөхцөлд | Жирийн нөхцөлд                       | Ноцтой нөхцөлд |
| <b>АТ-1</b>             | 2                      | 4              | 2                       | 4              | 1,0                                  | 1,5            |
| <b>АТ-2</b>             | 4                      | 6              | 4                       | 8              | 1,5                                  | 2,5            |
| <b>АТ-3</b>             | 4                      | 8              | 5                       | 10             | 2,5                                  | 4,0            |
| <b>АТ-4</b>             | 6                      | 12             | 8                       | 16             | 3,0                                  | 5,0            |
| <b>АТ-5</b>             | 7                      | 16             | 10                      | 20             | 3,0                                  | 6,0            |

*Тодруулга: 1. Цас цэвэрлэх хугацааны норм нь цас орж дуусмагц, шуурга зогссоны дараа буюу зам дээр халтиргаа гарч /ажиглагдаж/ эхэлснээс хойш, ТШ-д заасан шаардлагыг хангах ажил хийж дуусгах хүртэлх хугацаа юм.*

*2. АТ-4 ба АТ-5 ашиглалтын түвшингийн ХХМ цацах хугацааны норм нь замын аюултай хэсэгт зориулагдсан болно.*

*3. Эдгээр хугацааны норм нь Зам хариуцагч байгууллагын, хариуцсан замынхаа хэмжээнд ажил гүйцэтгэх хамгийн их хугацаа болно.*